

**“ХААН ДААТГАЛ” ХХК-ИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ “ОРОН СУУЦНЫ ИЖ БҮРЭН
ДААТГАЛ” БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МЭДЭЭЛЭЛ**

2018 оны 05 дүгээр сарын 11

№	Мэдээлэл	Бүтээгдэхүүний мэдээлэл
1	Даатгалын зүйл:	<ul style="list-style-type: none"> ➤ Орон сууцны хөрөнгө ➤ Орон сууц эзэмшигчийн хариуцлага
2	Даатгалын эрсдэлийн төрөл:	<ul style="list-style-type: none"> ➤ Галын ➤ Ус алдалтын
3	Даатгалын үнэлгээний дүн:	<ul style="list-style-type: none"> ➤ Орон сууцны хөрөнгө 1,300,000₮ ➤ Орон сууц эзэмшигчийн хариуцлага-1,300,000₮ ➤ Нийт 2,600,000₮
4	Даатгалын хураамжийн дүн /хувь/:	<ul style="list-style-type: none"> ➤ Орон сууцны хөрөнгө-Сарын 750₮, Жилийн 9,000₮ ➤ Орон сууц эзэмшигчийн хариуцлага-Сарын 750₮, Жилийн 9,000₮ ➤ Нийт сарын 1,500₮, Жилийн 18,000₮
5	Өөрийн хүлээх хариуцлага:	<ul style="list-style-type: none"> ➤ Өөрийн хүлээх хариуцлагагүй байна.
6	Даатгалын гэрээний үргэлжлэх хугацаа:	<ul style="list-style-type: none"> ➤ Гэрээний үндсэн хугацаа 5 жил ➤ Гэрээний хугацаа дуусахад талууд гэрээг цуцлах санал тавиагүй бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэсээр байгаа бол гэрээг үндсэн хугацаагаар сунгасанд тооцно.
7	Даатгагчийн эрх, үүрэг:	<ul style="list-style-type: none"> ➤ Даатгуулагчид даатгалын тухай хууль тогтоомж, гэрээний нөхцлийг танилцуулах ➤ Даатгалын тохиолдол болсон үед нөхөн төлбөрийг хууль болон гэрээгээр тохиролцсон хугацаа, хэмжээнд олгох ➤ Даатгагч хууль болон гэрээнд заасан үндэслэлээр даатгалын нөхөн төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн олгохоос татгалзах ➤ Даатгалын тохиолдол болсон үед түүний шалтгаан, нөхцлийг судлах, эрх бүхий байгууллагаар шалгуулах, шаардлагатай нэмэлт мэдээ, мэдээллийг даатгуулагчаас гаргуулж авах ➤ Даатгуулагчид учирсан хохирлыг нөхөн барагдуулсны дараа буруутай этгээдээс даатгалаар олгогдсон нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарсан зардлыг нэхэмжлэх эрхтэй.

		<ul style="list-style-type: none"> ➤ Хууль болон гэрээнд заасан бусад эрх үүрэг.
8	Даатгуулагчийн эрх, үүрэг	<ul style="list-style-type: none"> ➤ Даатгалын тохиолдол болсон үед гэрээний нөхцлийн дагуу нөхөн төлбөр олгохыг даатгагчаас шаардах эрхтэй. ➤ Даатгалын хураамжийн төлбөрийг хугацаанд нь төлөх, даатгагчийг үнэн зөв мэдээллээр хангах үүрэгтэй. ➤ Даатгуулагч энэхүү гэрээгээр нөхөн төлбөр олгогдож болох аливаа хохирлын талаар Даатгагчид нэн даруй буюу 72 цагийн дотор 75757588, 70000808, 99102584, 99102561 утсуудаар мэдэгдэх ➤ Даатгалын нөхөн төлбөрийг зориулалтын дагуу зарцуулах бөгөөд даатгалын тохиолдлын улмаас учирсан хохирлыг засварласны дараа даатгалын нөхөн төлбөр ахин авах эрхтэй. ➤ Нөхөн төлбөрийн материалыг өөрийн зардлаар бүрдүүлэн, даатгалын тохиолдол болсноос хойш хуанлийн 30 хоногийн дотор даатгагчийн хаягаар ирүүлэх үүрэгтэй. ➤ Даатгалын зүйлд аюул учрах нөхцөл байдлын тухай бичгээр мэдээлэх, даатгалтай холбоотой аливаа мэдээлэл, баримт бичгийг даатгагчид үнэн зөвөөр гаргаж өгөх ➤ Даатгалын зүйл болох орон сууцыг бусдын эзэмшил, өмчлөлд шилжүүлсэн бол Даатгагчид энэ тухайгаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ. ➤ Хууль болон гэрээнд заасан бусад эрх үүрэг.
9	Даатгалын нөхөн төлбөр олгоход бүрдүүлэх материал:	<ul style="list-style-type: none"> ➤ Даатгуулагчийн өргөдөл, байгууллага бол албан бичиг ➤ Даатгалын гэрээт баталгаа ➤ Даатгалын гэрээ хийгдсэн буюу даатгалын тохиолдол болсон орон сууцны даатгалын хураамж төлсөн сүүлийн 2 сарын баримт ➤ Даатгуулагчийн иргэний цахим үнэмлэхний хуулбар /хаяг таараагүй бол ҮХХ-ийн гэрчилгээний хуулбар/ ➤ Нөхөн төлбөрийг хүлээн авах даатгуулагчийн банкны харилцах дансны дугаар ➤ Зайлшгүй шаардлагатай тохиолдолд бусад баримт бичиг буюу мэргэжлийн байгууллагын бичгээр гаргасан хохирлын акт, дүгнэлт

10	Даатгалын нөхөн төлбөр олгох хугацаа:	<ul style="list-style-type: none"> ➤ Дээр заасан материалуудыг бүрэн хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан нөхөн төлбөрийн асуудлыг шийдвэрлэнэ.
11	Даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзах нөхцөл:	<ul style="list-style-type: none"> ➤ Эд хөрөнгийн ердийн элэгдэл, хорогдол, ууршилт, дээврийн цооролт, мөөгөнцөрдөх, өмхрөх гэх мэт тухайн эд хөрөнгийн шинж чанараас шалтгаалан гарсан хохирол; ➤ Орон сууцандаа засвар хийх явцдаа даатгалын тохиолдол бий болгосон эсхүл зориулалтыг өөрчлөх, ашиглалтын горим зааврыг зөрчсөн, даац, бүтээц өөрчлөх, зориулалтын бус тоног төхөөрөмж тавьсан, суурилуулснаас үүдэн гарсан хохирол; ➤ Ил далд шугам солих зардал болон түүнийг засварлахтай холбогдон гарсан хохирол; ➤ Даатгалын тохиолдлыг нотлох боломжгүй буюу сэргээн засварласны дараа мэдэгдсэн үед; ➤ Даатгалын гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй үед;
12	Даатгуулагч даатгалын гэрээнээс татгалзах тохиолдолд даатгуулагчид даатгалын хураамжийн буцаалтыг тооцож, олгох нөхцөл:	<ul style="list-style-type: none"> ➤ Даатгалын гэрээг хугацаанаас нь өмнө цуцлахад хүрвэл гэрээ цуцлагдаж буй өдрөөс хойш үлдсэн хугацаанд ногдох даатгалын хураамжийг доорхи тооцооллын дагуу Даатгуулагчид буцаан олгоно. ➤ $x = \left(\text{Хураамж} - \frac{\text{Хураамж} * \text{Даатгал үйлчилсэн хоног}}{\text{Гэрээний хүчинтэй өдрүүд}} \right)$

Мэдээлэл бэлтгэсэн:

Л. Оргил Шууд борлуулалт, сувгийн удирдлагын хэлтсийн захирал

Хянасан:

Д. Жаргал Дэд захирал, Даатгалын газрын захирал